АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ТОГТООЛЫН 2024 ОНЫ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ
(Шинэжинст сум)

2024 оны 06 дугаар сарын 05 Залаа

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Аймгийн ИТХ-ын тогтоол | | | | | | | |
| 1 | 1 | Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр батлах тухай 2021-12-14 Дугаар 2021_131 | 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай | Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн баримт, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр батлах тухай” тогтоол батлагдсантай холбогдуулан сумдын хогийн цэгийг шинээр байгуулах чиглэлийн дагуу тус сум нь 2023 онд хог хаягдлын цэгийг дарж булшлах, шинээр байгуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Сумын Засаг даргын Тамгын газраас хогийн цэгийг дарж булшлах, шинээр байгуулах ажлын даалгавар, төслийг боловсруулж, санхүүжилтийг уул уурхайн аж ахуйн нэгжид тавьж ажилласнаар тус суманд ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Эрдэнэмонгол ХХК уг хүсэлтийг хүлээн авч Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг “Талын нөмөр” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээлгэн өгсөн. 2024 онд хог ачигч машин эвдрэл гэмтэл гарсны улмаас өрхийн хог хаягдлыг ачих зөөвөрлөх ажлыг 2 сарын хугацаанд гүйцэтгэж чадаагүйгээс үүдэн хувиараа хог ачиж асгаж хогийн цэгт хог бутарч асгагдсан. Үүнийг ковш | 100% | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тракторoоp түрэх ажлыг хувийн аж ахуйн нэгжтэй хамтран 2 удаа гүйцэтгэж, хогийн цэгийн ашиглалт сайжирсан үр дүнтэй байна. | | | |
| 2 | 2 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангийн дүрэм баталж, зөвлөл байгуулах тухай 2021-12-22 Дугаар 2021_144 | 1. Сангийн дүрмийг олон нийтэд сурталчилж, ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хамтран ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай | Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 4 багийн Иргэдийн нийтийн хурлаар 300-аад малчдад сурталчилж, сан байгуулах тухай хэлэлцүүлэхэд хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь "Манай суманд мал хулгайлах гэмт хэрэг гардаггүй, малчдын хариулга маллагаа сайн" байдаг учраас сан байгуулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. | 100% | 100% | |
| 3 | 3 | Эдийн засгийг сэргээн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг бий болгох "Баялаг бүтээгч-Баянхонгор" хөтөлбөр батлах тухай 2021-12-24 Дугаар 2021_7/30 | 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай. | Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ард иргэдийн гарааны бизнесийг дэмжих зорилгоор "Эрдэнэ Монгол" ХХК-аас нийт 100000000 (Нэг зуун сая) төгрөгийн санхүүжилттэй "Бичил зээл" хөтөлбөрийг 05 дугаар сараас хэрэгжүүлж эхлэн сумын ЖДҮ эрхлэгчдээс төсөл хүлээн авч байна. Энэхүү хөтөлбөр нь ХААН банкаар дамжин олгогдох ба 3 жилийн хугацаатай, хүүгүй зээл юм. Бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэх сонирхол бүхий ард иргэдийг чадавхжуулах, сургаж дадлагажуулах, төсөл боловсруулах сургалтыг "Хөгжлийн шийдэл" ТББ-ын BEST хөтөлбөрийн сургагч багш нартай хамтран зохион байгуулсан. Эхийн голын Баянбүрдийн газар тариалан эрхлэгчдэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ерөнхий агрономич Б.Мөнхтогтох, Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Г.Золбоо, зөвлөх агрономич Н.Алтантуяа нар 2024 оны 04 сарын 20-ны өдөр тариалангийн талбайн | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглалт, таримлын сэлгээ, хөрс боловсруулалт, үр суулгацын материалыг тариалалтад бэлтгэх, ургалтын үеийн технологийн мөрдөлт, усалгаа, ургамал хамгаалах химийн болон биологийн арга, химийн бодис, бордоо хэрэглэх, хөнөөлт шавж, ашигт бичил биет, хог ургамал, ургамлын өвчин зэрэг сэдвээр сургалт зохион байгуулав. Сургалтад 18 тариалан эрхлэгч хамрагдаж тариалан эрхлэхэд өөрсдөд тулгардаг асуудал, санал бодлоо солилцож зөвлөгөө авч харилцан туршлага солилцлоо. Хөдөө аж ахуйн 9 хоршоонд Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргүүлж "Цармын цагаан сувд" хоршооны дарга З.Амартүвшин, "Залаа шинэ эргэлт" хоршооны дарга О.Бямбатогоо, малчин Ш.Батнасан, "Залаажинст торгон сүрэг" хоршооны малчин Х.Дашпунцаг, "Өсөх Залаажинст" хоршооны гишүүн Ч.Уранбилэг нарыг Улаанбаатар хотод сургалтад хамруулав. | | | |
| 4 | 4 | Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 2023-12-05 Дугаар 2023_17/59 | 1. Хөгжлийн төлөвлөгөөг олон нийтэд сурталчилж, салбар дундын хамтын ажиллагааг хангаж, арга хэмжээ бүрийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай. | 2024 оны Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг албан хаагчдад танилцуулж Сумд хамааралтай заалтуудыг сумын 2024 оны сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 100 дугаар тогтоолоор баталсан. Хагас хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргахаар төлөвлөж байна. | 100% | 30% | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 5.2.2 дахь заалтын дагуу тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой тайлагнах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан нөхцлийг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тодорхой дурдах, 9.3 дахь заалтын дагуу тайланг нотлох баримттай тайлагнах./хэдэн заалттай төлөвлөлт, хэрэгжилтийн хувь |
| 5 | 5 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх /2023-2026он/ арга хэмжээний төлөвлөгөө тухай 2023-12-05 Дугаар 2023_17/68 | 1. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутаг, холбогдох салбарын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны хяналт шинжлэгээг тогтмол, үнэлгээг 2 жил тутам хийж, биелэлтийн мэдээг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах, салбар дундын хамтын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар Сумын Засаг даргын захирамжийн ажлын хэсэг байгуулагдан, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 3 болон 4 дүгээр улиралд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнүүд байгаа. Зарцуулсан төсөв байхгүй. | 70% | 30% | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 5.2.2 дахь заалтын дагуу тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой тайлагнах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан нөхцлийг тодорхой дурдах, 9.3 дахь заалтын дагуу тайланг нотлох баримттай тайлагнах./Хийсэн ажлыг тоо баримттай тайлагнах |
| Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 6 | “Ухаалаг Баянхонгор” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2019-01-31 Дугаар 2021_02 | 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, зохион байгуулах ажлыг аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган батлуулан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай. | Ухаалаг Баянхонгор хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын Тамгын газраас иргэдээс хамгийн асуугддаг и-монголиа ашиглалтын талаар видео бичлэг хийж, албан ёсны группэд байршууллаа. Мөн цахим хурлын төхөөрөмжийг ОНХС-н хөрөнгөөр 20 сая төгрөгийг зарцуулж ажиллалаа. | 100% | 30% | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 5.2.2 дахь заалтын дагуу тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой тайлагнах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан нөхцлийг тодорхой дурдах, 9.3 дахь заалтын дагуу тайланг нотлох баримттай тайлагнах./тоон гарын үсэг, цахим системүүдийн хэрэглээ ашиглалтын хувь |
| 7 | 7 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөр | 1. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулан, хэрэгжилтийг хагас бүтэн | Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт 4 удаа зохион байгуулж 195 иргэн хамрагдсан байна. Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн харилцаа зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. | 70% | Хугацаа болоогүй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | батлах тухай 2020-08-26 Дугаар 2021_71 | жилээр аймгийн иргэдийн Төлөөлгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай. | | | | |
| 8 | 8 | “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2020-09-14 Дугаар 2021_90 | 1. Хоршоодын хамрах хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх, хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд тусгаж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай. | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны “Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2024 оны төсөв батлах тухай” 103 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтаар “Хоршоог хөгжүүлэх сан”-гаас 2024 онд 112215000 (Нэг зуун арван хоёр сая хоёр зуун арван таван мянга) төгрөгийн зээл олгохоор тусгаж шийдвэрлүүлээд "Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргаж 2023 онд 10 сая төгрөг, 2024 оны 1 сард 30 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон. Мөн хоршоодод болон зээлдэгчдэд дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах сургалт сурталчилгааны зардалд Хоршоог хөгжүүлэх сангаас 1156000 (Нэг сая нэг зуун тавин зургаан мянга) төгрөгийн санхүүжилтийг тусган сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | 70% | 70% | |
| 9 | 9 | “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөр батлах тухай 2020-11-15 Дугаар 2021_59 | 1. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулан, | Хэрэгждэггүй тул хасуулах саналтай байна. | Хугацаа болоогүй | 0% | |

# АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ТОГТООЛЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Өөрийн үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 05 Залаа

| | | | |
|---|---|---|---|
| АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ТОГТООЛЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 9 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **4** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **4** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **-** |
| | Үр дүнгүй | **0%** | **-** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | 1 |
| | Аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоолын 2023 оны хагас жилийн хэрэгжилт **85%** хувьтай байна. | | |

оОо

# АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ТОГТООЛЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 05 Залаа

| АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ТОГТООЛЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 9 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **2** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **2** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **3** |
| | Үр дүнгүй | **0%** | **1** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | 1 |
| | Аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоолын 2024 оны хагас жилийн хэрэгжилт **48%** хувьтай байна. | | |

________________oOo________________

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай. | | | | |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ